



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 11 сарын 15 өдөр

Дугаар 9/616

Мөрөн сум

Ажлын хэсгийг шинэчлэн байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1, Засгийн газрын 2017 оны “Захиалагчийн дүрэм батлах тухай” 170 дугаар тогтоол, Засгийн газрын 2023 оны “Журам батлах тухай” 278 дугаар тогтоол, 2024 оны 10 сарын 23-ны өдрийн Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны сайдын 02/3383 дугаар албан бичгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Орон нутгийн хөгжлийг дэмжих “Шинэ хөдөө” төсөл (Хөвсгөл) УТ2401900387 төсөл, арга хэмжээ гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээтэй холбоотой асуудлаар захиалагчийг төлөөлж харилцах, нийлүүлэх барааны чанар байдал, гэрээний нөхцөлүүдийн хэрэгжилтэд хяналт тавих чиг үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: -Хүнс, хөдөө аж ахуйн газрын, үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээний албаны дарга

Ажлын хэсгийн гишүүд: -Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн Хүнс, хөдөө аж ахуйн бодлого, үйл ажиллагааг зохион байгуулах ахлах мэргэжилтэн
-Хөдөөгийн шийдэл ХХК-н захирал
-Аймгийн орон нутгийн өмчийн удирдлага, зохицуулалт хариуцсан мэргэжилтэн
-Хүнс, хөдөө аж ахуйн газрын, үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээний албаны мэргэжилтэн

Нарийн бичгийн дарга: -Хөдөөгийн шийдэл ХХК-ийн нягтлан бодогч

2. “Шинэ хөдөө” төслийн хүрээнд нийлүүлэгч аж ахуй нэгжүүдийн гэрээний нөхцөлүүдийн хэрэгжилтэд хяналт тавих, тоног төхөөрөмжийг, хүлээн авсан акт, тэмдэглэл баталгаажуулсан зураг, Орон нутгийн өмчийн газар барааг хүлээн авсан тодорхойлолт, хөрөнгө бүртгэсэн маягт зэрэг баримт бичгийг бүрдүүлж ажиллахыг Ажлын хэсгийн ахлагч (Б.Цолмонбаяр)-д даалгасугай.

3. Энэ захирамж гарсантай холбогдуулан Аймгийн Засаг даргын 2024 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн А/607 дугаар захирамж, Орон нутгийн хөгжлийг дэмжих “Шинэ хөдөө” төсөл (Хөвсгөл) багц-3 хүлэмж нийлүүлэх 241023/05-831 тоот гэрээгээр 2024.11.11 өдөр нийлүүлсэн “Хүлэмж хүлээн авсан комиссын акт тус тус хүчингүй болсонд тооцсугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын албан үүрийг түр орлон гүйцэтгэгч (Г.Гандэлгэр)-т үүрэг болгосугай.

ДАРГА

П.ТӨМӨРБААТАР

Захирамж2024

6712011864